



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 8 сарын 14 өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.24 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “БАТС ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Лувсан овогтой Итгэлтийг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Гүйцэтгэх захирлыг өөрчлөн томилсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “БАТС ҮЦК” ХХК /Л.Итгэлт/-д үүрэг болгосугай.

1/ Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

2/ Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН